

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 70432545

цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
Н.ТУНГАЛАГ ТАНАА

2022.02.22 № 2165
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Н.БОЛДБААТАР



021020162

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,494,668.40</u>	<u>82,397,462.51</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	520,268.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	520,268.26
3121	Төгрөг	00.00	520,268.26
31211	Төрийн сангийн харилцах	00.00	499,877.68
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	20,390.58
33	АВЛАГА	00.00	37,646,104.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,315,104.21
335	Бусад авлага	00.00	36,331,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	36,331,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,494,668.40	44,231,090.04
351	Түүхий эд материал	17,708,451.00	23,206,482.00
35130	Эм боох материал	17,708,451.00	23,206,482.00
354	Хангамжийн материал	11,788,977.40	17,429,608.04
35410	Бичиг хэргийн материал	776,550.00	1,432,150.00
35420	Аж ахуйн материал	6,413,893.40	11,751,384.04
35440	Түлш, шатах тослох материал	426,000.00	213,000.00
35460	Хүнсний материал	2,353,460.00	2,214,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,819,074.00	1,819,074.00
35600	Мал амьтад	997,240.00	3,595,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>383,822,920.14</u>	<u>378,925,031.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	383,822,920.14	378,925,031.63
392	Биет хөрөнгө	347,822,920.14	342,925,031.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	266,465,857.00	266,465,857.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,904,942.08	-20,529,288.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,531,833.00	66,031,833.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,211,222.28	-40,879,861.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,555,468.00	181,095,688.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,649,193.48	-123,744,702.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,712,220.00	20,972,220.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,455,450.02	-8,265,064.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,631,550.00	1,631,550.00
39217	Ном	146,800.00	146,800.00
393	Биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>414,317,588.54</u>	<u>461,322,494.14</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>32,440,928.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	32,440,928.00
413	Өглөг	00.00	32,440,928.00

4136	Бусад өглөг	00.00	32,440,928.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	32,440,928.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	414,317,588.54	428,881,566.14
51	Засгийн газрын хувь оролцоо	414,317,588.54	428,881,566.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		349,821,565.00	349,821,565.00
51101	Өмч: - төрийн	349,821,565.00	349,821,565.00
512	Хуримтлагдсан үр дүн	-46,674,612.81	-32,110,635.21
51210	Өмнөх үеийн үр дүн	-46,674,612.81	-56,243,322.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,132,687.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,170,636.35	111,170,636.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	414,317,588.54	461,322,494.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	532,017,576.00	737,798,357.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	445,377,163.00	34,284,004.02
120	Нийтлэг татварын бус орлого	28,333,795.00	34,284,004.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,333,795.00	34,284,004.02
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,333,795.00	34,284,004.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	86,640,413.00	703,514,353.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,498,593.00	53,182,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,498,593.00	53,182,733.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,130,400.00	27,385,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,130,400.00	27,385,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	418,835,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	418,835,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	33,011,420.00	204,111,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,011,420.00	204,111,020.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	506,369,038.49	712,668,429.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,369,038.49	712,668,429.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,964,508.41	678,227,598.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,593,155.00	367,667,499.21
210101	Үндсэн цалин	298,593,155.00	367,667,499.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,153,134.92	49,103,394.00
210201	Тэтгэврийн даатгал	37,153,134.92	49,103,394.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,313,300.00	24,729,169.00
210301	Гэрэл, цахилгаан	514,800.00	416,669.00
210302	Түлш, халаалт	20,798,500.00	18,492,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	5,820,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	57,870,143.00	45,993,302.32
210401	Бичиг хэрэг	3,597,860.00	4,224,810.00
210402	Тээвэр, шатахуун	30,374,420.00	39,622,905.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,776,000.00	1,867,097.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	565,700.00	278,490.00
2105	Нормативт зардал	16,052,990.00	142,671,850.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,113,800.00	136,417,340.38
210502	Хоол, хүнс	3,939,190.00	6,254,510.00
2107	Томилолт, зочны зардал	2,360,400.00	756,000.00
210702	Дотоод албан томилолт	2,360,400.00	756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,800.00	806,325.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	200,925.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	333,500.00	405,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,790,817.49	46,500,058.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,259,720.00	13,301,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,531,097.49	33,198,108.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,404,530.08	34,440,831.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	32,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	32,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,104,530.08	1,640,831.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,104,530.08	1,640,831.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	25,648,537.51	25,129,927.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	997,240.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	997,240.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-997,240.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	25,648,537.51	24,132,687.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-46,674,612.81	414,317,588.54
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-46,674,612.81	414,317,588.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-9,568,710.00	-9,568,710.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-56,243,322.81	404,748,878.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,132,687.60	24,132,687.60
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-32,110,635.21	428,881,566.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	466,954,013.00	667,183,353.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	380,313,600.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	380,313,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	380,313,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	86,640,413.00	667,183,353.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,498,593.00	53,182,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,498,593.00	53,182,733.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,130,400.00	27,385,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,130,400.00	27,385,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	418,835,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	418,835,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	33,011,420.00	167,780,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,011,420.00	167,780,020.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	466,014,013.00	666,663,084.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	466,014,013.00	666,663,084.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,609,482.92	632,222,253.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,359,100.00	377,284,574.42
210101	Үндсэн цалин	195,782,700.00	232,486,313.29
210102	Нэмэгдэл	69,091,600.00	113,756,407.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	4,869,911.11
210104	Урамшуулал	18,884,800.00	25,679,197.51
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	492,745.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,554,189.92	40,801,423.00
210201	Тэтгэврийн даатгал	27,394,100.00	29,825,356.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,782,502.59	2,569,076.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,092,792.69	2,485,022.49
210204	Ажилгүйдлийн даатгал	523,297.00	525,308.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,761,497.64	5,396,659.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,351,300.00	24,516,169.00
210301	Гэрэл, цахилгаан	514,800.00	416,669.00
210302	Түлш, халаалт	18,836,500.00	18,279,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	5,820,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,674,420.00	47,866,662.32
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	4,934,910.00
210402	Тээвэр, шатахуун	30,374,420.00	38,564,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,867,097.32

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	31,825,685.00	122,644,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,647,085.00	112,667,500.00
210502	Хоол, хүнс	6,680,600.00	5,977,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,498,000.00	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,557,868.00	9,913,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	8,685,000.00
210604	Урсгал засвар	15,557,868.00	1,228,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,360,400.00	756,000.00
210702	Дотоод албан томилолт	2,360,400.00	756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,983,500.00	856,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,304,700.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	333,500.00	455,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,943,020.00	7,583,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,943,020.00	7,583,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,404,530.08	34,440,831.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	32,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	32,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,104,530.08	1,640,831.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,104,530.08	1,640,831.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	940,000.00	520,268.26
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	940,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	940,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	940,000.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	940,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-940,000.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	520,268.26
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	520,268.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	481,569,800.00	475,309,520.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,569,800.00	475,309,520.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,369,800.00	475,309,520.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,983,500.00	331,900,697.00
210101	Үндсэн цалин	209,091,500.00	232,486,313.29
210102	Нэмэгдэл	91,501,000.00	68,372,529.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	4,869,911.11
210104	Урамшуулал	25,091,000.00	25,679,197.51
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	492,745.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,817,800.00	40,801,423.00
210201	Тэтгэврийн даатгал	31,538,400.00	29,825,356.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,319,800.00	2,569,076.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,655,900.00	2,485,022.49
210204	Ажилгүйдлийн даатгал	664,000.00	525,308.07
210205	Эрүүл мэндийн даатгал	6,639,700.00	5,396,659.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,156,900.00	24,516,169.00
210301	Гэрэл, цахилгаан	2,057,400.00	416,669.00
210302	Түлш, халаалт	18,279,500.00	18,279,500.00
210303	Цэвэр, бохир ус	5,820,000.00	5,820,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,090,000.00	35,957,097.32
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,390,000.00	30,390,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,867,097.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	33,237,100.00	33,114,194.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,137,100.00	23,137,094.00
210502	Хоол, хүнс	6,100,000.00	5,977,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,228,100.00	2,228,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,228,100.00	1,228,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	756,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	856,400.00	856,325.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	200,925.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	455,400.00	455,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	4979615.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,979,615.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200000.00	200000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	481,569,800.00	475,829,789.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,835,600.00	418,835,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,835,600.00	418,835,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,385,000.00	25,744,169.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,385,000.00	25,744,169.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,349,200.00	31,250,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,349,200.00	31,250,020.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	520,268.26
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,498,593.00	189,692,342.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,498,593.00	189,692,342.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,498,593.00	189,692,342.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,000,000.00	45,383,877.42
210101	Үндсэн цалин	2,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	36,000.00	11,909,565.00
210402	Тээвэр, шатахуун	36,000.00	8,174,655.00
2105	Нормативт зардал	6,189,725.00	89,530,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,683,725.00	89,530,400.00
210502	Хоол, хүнс	506000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,329,768.00	7,685,000.00
210604	Урсгал засвар	14329768.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1000000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1000000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1943100.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1943100.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,498,593.00	189,712,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,498,593.00	189,712,733.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,390.58

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөтөлбөр арга хэмжээний зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор А.Нарандэлгэр 2022 оны 02 дугаар сарын 18-с 2021 оны 02 дугаар сарын 22-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Алтай сумын эрүүл мэндийн төв нь “*Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сумынхаа ард иргэдэд мэргэжлийн өндөр түвшинд тэгш хүртээмжтэй шуурхай чанартай үйлчилгээг үзүүлнэ*” гэсэн эрхэм зорилго тавин ажилласан байна.

Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан, хүн амын эрүүлжүүлэх үйлсэд уламжлалт анагаах ухааныг өргөн ашиглах, ард иргэдэд эрүүл мэндийнхээ төлөө зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх явдал тухайн байгууллагын үйл ажиллагааны гол чиг үүрэг болон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04-р сарын 30-ны 67/А268 тоот тушаалаар “*ковид-2019 эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай*”
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07-р сарын 26-ны А/496 тушаалаар “*ковид-2019 эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах мөнгөн тэтгэмж олгох*” тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад 2021 онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт зарлагын 716.2 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 10.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47.0 сая төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба эцэст 0.5 сая төгрөг байна

Бараа материалын дансны үлдэгдэл 44.2 сая төгрөг болж 13.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 5.5 сая төгрөг, хангамжийн материал 5.6 сая төгрөгөөр, мал амьтад 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 206.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 13.8 сая төгрөгөөр нийт 220.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 200.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эцэст 37.1 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны цэвэр үлдэгдэл оны эхэнд 383.8 сая төгрөг байсан бол оны эцэст 378.9 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 544.6 сая төгрөг байсан бол оны эцэст 572.9 сая төгрөг болж 28.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 7.8 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 20.5 сая төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Тайлант оны эцэст 32.4 сая төгрөгийн өр үүссэн байгаа нь тээвэр шатахууны зардлын өр 1.0 сая төгрөг, эмийн өр 31.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 414.3 сая төгрөг байсан оны эцэст 428.8 сая төгрөг болж тайлант онд өөрчлөлт гарсан нь тайлант оны үр дүн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 9.5 сая төгрөгөөр бичилт хийгдэж тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 32.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр 416.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 30,1 сая төгрөгөөр, ЭМД-аас 32.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 478.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ЭМГ-аас тус байгууллагын төсвийг төсвөөс 418.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 27.4 сая төгрөг, ЭМД-аас 35.3 сая төгрөг нийт 481.6 сая төгрөг батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 481.6 сая төгрөгийн төсөв баталснаас 418.8 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 27.4 сая төгрөг, ЭМД-аас 35.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ЭМГ-аас төсвийн санхүүжилтийг 418. сая төгрөг, орон нутгийн төсвөөс 25.7 сая төгрөг, ЭМД-аас 31.3 сая төгрөгөөр нийт 475.8 сая төгрөгөөр санхүүжүүлж ЭМД-аас санхүүжих санхүүжилтийг эрүүл мэндийн үйлчилгээний гүйцэтгэлээр 4.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 475.9 сая төгрөг буюу 98.7 хувь зарцуулж төсвийн хэмнэлт гаргаагүй тайлант оны үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвийн хэмжээнд бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн ЭМГ-аас ковид-2019 цар тахлын үеэр ажилласан илүү цаг, томилолт, вакцины урамшуулал болох 157.1 сая төгрөг, ЭМЯ-наас сайдын тушаалаар эрүүл мэндийн ажилчдын нэг удаагийн буцалтгүй тусламж 32.6 сая төгрөг нийт 189.7 сая төгрөгийн санхүүжилт авч өр, 36.3 сая төгрөгийг авлагагүй бүрэн зарцуулсан харилцах дансанд үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсноор Ковидын үед эрүүл мэндийн төвийн эм тариа тасарч, өвчтөн хувиасаа эм тариа гаргаж хэрэглэсэн 6 хүний өргөдлийг тус байгууллагад ирүүлсэн боловч шийдвэрлээгүй байсныг аудитын явцад буцаан олгуулж залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх эрүүл мэндийн даатгалын сангаас авах 36.3 сая төгрөгийн авлага, байгууллагад төлөх 32.4 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 66.7 хувьтай мэдээлсэн байна. Ховд аймгийн Алтай сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрснийг аудитын явцад залруулаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 119.0 сая төгрөгийн алдаа зөрчлийн 1 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдсөнөөс 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 95.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 0.9 сая төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 17.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3.9 сая төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал эмийн тайланг зохих ёсоор гаргадаггүй, эмийн зарлагыг үлдэгдлээс хөөж гаргаж байгааг дараагийн аудитаар авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн төлбөрийн 2 акт, 17.7 сая төгрөгийн 3 залруулга, 2.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 5.0 сая төгрөгийн 1 зөвлөмж, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 залруулга хийсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой

1. Тайлант оны үр дүнгийн тайлангийн цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, тээвэр шатахууны зардлыг буруу тайлагнасан 7.5 сая төгрөг,
2. Нийгмийн даатгалын тайланг зөрүүтэй илэрхийлж авлагаар тусгаагүй 0.5 сая төгрөг,
3. Эмийн тайлангийн оны эхний үлдэгдлийг тооллого хийж баталгаажуулахдаа үнийн дүнг зөрүүтэй илэрхийлсэн 9.6 сая төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 17.6 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 22-ны 14 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

1.2 Шилэн данстай холбоотой

Илрүүлэлт: Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 66.7 хувьтай мэдээлсэн байна. Ховд аймгийн Алтай сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэлт: Санхүүжилтийн орлогын 10 мэдээлэл, зарлагын 1 мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн мэдээллийг аудитын хугацаанд шилэн дансны сайтад нөхөн оруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. ХАОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулах тооцсон 0.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт / 0- 6,0 сая төгрөгийн орлогод 0,24 сая төгрөг /дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

2. Үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэлтэй эмч, албан хаагчдад олгосон 1.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Эрхлэгч эмч, дотрын их эмч нарт ЭХО, хүүхдийн их эмчийн ажил хавсарсны нэмэгдэл олгосон 2.8 сая төгрөгийг зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилтийг холбогдох хууль, тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй 5.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан,

баталгаажуулах”, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын холбогдох заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын Эрүүл мэндийн төв	8	27.2	3	17.7	2	1.7	1.	2.8	1	5.0

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар